



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 08 сарын 13 -ны өдөр

Дугаар А/82


Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 29.6, Монгол улсын засгийн газрын 2019 оны “ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ” 193 дугаар тогтоолын 5.1.11, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 340 дүгээр тушаал, Эрүүл мэндийн газрын 2019 оны 10 сарын 01-ний өдрийн “Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай” журмын 7.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор биохимийн шинжилгээнд хамруулах арга хэмжээний зардлыг хавсралтаар баталж, “Оношлаб” ХХК-ны Онош лабораторитай 2021 оны 08 сарын 25-ны өдрөөс хамтран ажиллах гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.
2. Зардалд шаардагдах 640,000 /зургаан зуун дөчин мянган/ төгрөгийг төсөл хөтөлбөрийн зардлаас гаргахыг салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.
3. Үйл ажиллагааг зохион байгуулахыг эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал шагнал урамшуулал хариуцсан мэргэжилтэн /С.Мөнхзул/-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ